

“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 06 дугаар

№01

Улаанбаатар

хот

сарын 12-ны өдөр

Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 17 дугаар зүйлийн 17.1, “Хөвсгөл Алтан дуулга” ХК-ийн дүрмийн 7.7.1 дэх заалтыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг. “Хөвсгөл Алтан дуулга” ХК-ийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг Монгол Улсын Сангийн сайд, Статистикийн хорооны дарга нарын 2018 оны 319/А/160 дугаартай хамтарсан тушаалаар баталсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-д заасан агуулга, нэршлийн дагуу дор дурдсан ёсоор тогтоож компанийн дүрмийн 3.2 дах заалтыг өөрчлөн найруулсугай:

1) 3.2 Компани дараах үндсэн үйл ажиллагааг эрхэлнэ:

- “3.2.1 0111- Үр тариа (цагаан будааг оруулахгүйгээр), буурцагт болон тосны ургамал тариалалт;**
- 3.2.2 0119- Бусад төрлийн нэг эсхүл хоёр наст ургамал тариалалт;**
- 3.2.3 0161- Газар тариалангийн салбарын туслах үйл ажиллагаа;**
- 3.2.4 0163- Ургац хураалтын дараах хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах үйл ажиллагаа;**
- 3.2.5 0164- Тарих үрийг боловсруулах үйл ажиллагаа;**
- 3.2.6 1040- Ургамлын болон амьтны гаралтай тос үйлдвэрлэл;**
- 3.2.7 1061- Үр тарианы гурилын үйлдвэрлэл;**
- 3.2.8 1080- Малын тэжээлийн үйлдвэрлэл;**
- 3.2.9 2012- Бордоо, азотын нэгдлийн үйлдвэрлэл;**
- 3.2.10 2021- Хөдөө аж ахуйн химийн бүтээгдэхүүн болон хортон шавжтай тэмцэх бүтээгдэхүүний үйлдвэрлэл;**
- 3.2.11 3821- Аюулгүй хог хаягдлыг боловсруулах, зайлуулах;**
- 3.2.12 4610- Төлбөр эсхүл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа (гадаад, дотоод худалдаа);**
- 3.2.13 4620- Хөдөө аж ахуйн түүхий эдийн худалдаа;**
- 3.2.14 4669- Дээр дурдсан ангид ороогүй хог хаягдал, хаягдал төмөр, бусад бүтээгдэхүүний бөөний худалдаа;**
- 3.2.15 Хууль тогтоомжоор хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа.”**

Хоёр. “Хөвсгөл Алтан дуулга” ХК-ийн Дүрмийн дараах зүйл, заалтыг дор дурдсан ёсоор өөрчлөн найруулсугай:

1) 7.6 дах заалт:

“7.6 Дараах тохиолдолд ТУЗ хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна:

7.6.1 ТУЗ-ийн нийт гишүүний 50-с дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;

- 7.6.2 ТУЗ-ийн 2 буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч зохих ёсоор санал, шаардлага гаргасан нь үндэслэлтэй гэж ТУЗ шийдсэн;
- 7.6.3 Компанийн өр нь хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болсон;
- 7.6.4 ТУЗ шийдвэр гаргасан;
- 7.6.5 Аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийхийг шаардсан;
- 7.6.6 Компанийн дүрэмд заасан бусад.”
- 2) 7.7 дах заалт:
“бүрэн эрхэд хамаарах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн” гэснийг “бүрэн эрхэд хамаарах бөгөөд хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн” гэж,
- 3) 7.8 дах заалт:
“бүрэн эрхэд хамаарах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн” гэснийг “бүрэн эрхэд хамаарах бөгөөд хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн” гэж,
- 4) 7.27 дох заалт:
7.27.1 овог, нэр, нас, хүйс;
7.27.2 боловсрол, мэргэжил;
7.27.5 нэр дэвшигч нь компанитай харилцан хамаарал байгаа эсэх;
7.27.8 орлогын эх үүсвэр, болон түүний ТУЗ-ийн гишүүний ажил үүрэгт нөлөөлөхүйц бусад нөхцөл байдлын талаарх мэдээлэл.”
- 5) 7.8.2, 7.31.4, 7.31.15 дах заалтуудад:
“хувь нийлүүлэгч” гэснийг “хувьцаа эзэмшигч” гэж
- 6) 7.56 дах заалт:
“хөлсөөр ажиллах гэрээгээр” гэснийг “гэрээгээр” гэж
- 7) 7.57 дох заалт:
“ТУЗ-ийн төлөөлөн дарга” гэснийг “ТУЗ-ийн дарга” гэж
- 8) 8.2.3 дах заалт:
“шийдвэр гаргах, шийдвэр гаргах ажиллагаанд оролцохдоо” гэснийг “шийдвэр гаргахдаа” гэж
- 9) 10.1 дэх заалт:
“Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг” гэснийг “Ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг” гэж
- 10) 13 дугаар зүйлийн гарчиг:
“Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах” гэснийг “Бусад” гэж
- 11) 14 дүгээр зүйл:
“Дүрэм хүчин төгөлдөр болох” гэсэн гарчгийг бүхэлд нь хасаж,
“14.1” дэх заалтын дугаарыг “13.3” гэж
“14.2” дах заалтын дугаарыг “13.4” гэж тус тус өөрчлөн найруулсугай.

Гурав. “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн Дүрэмд дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

- 1) 7.7 дах заалт:
“7.7.6 компанийн хэлбэрийг өөрчлөх”
- 2) 7.31 дэх заалтын гарчиг:
“ТУЗ-ийн бүрэн эрх:”
- 3) 7.43 дах заалтын гарчиг:
“ТУЗ-ийн дарга”

Дөрөв. Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон холбогдох бусад нэмэлт, өөрчлөлтийг тусгасан “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

Тав. “Хөвсгөл Алтан дуулга” ХК-ийн дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлтийг төрийн эрх бүхий байгууллагад хуульд заасан хугацаанд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Бат-Эрдэнэ), Төлөөлөн Удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (М.Зулзаяа) нарт тус тус даалгасугай.

Зургаа. “Хөвсгөл Алтан дуулга” ХК-ийн дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлтийг төрийн эрх бүхий байгууллага бүртгэснээр дүрмийн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.НАРАН-УЧРАЛ